

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
Халамжийн сангийн /орон нутгийн төсөө/ 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/52-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
4. Аудитын тайлан	11-14
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГБААТАР ТАНАА

2023.02.17 № 68А-2023/-НАСТА ТУС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд орон нутгийн төсвөөс 154,820.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос нийт 239 иргэнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж зэрэгт 132,095.8 мянган төгрөгийг зарцуулж, 22,724.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн 132,095.8 мянган төгрөгийн 76,800.0 мянган төгрөг буюу 58.1 хувийг онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих

мөнгөн тэтгэмжийн зарцуулалт, 47,597.0 мянган төгрөг буюу 36 хувийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт эзэлж байна.

Тайлант онд халамжийн үйлчилгээ цахим системд нэвтэрснээр иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ цахимаар илгээж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		
31210	Төгрөг		
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
33	АВЛАГА		
33500	Бусад авлага		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ		
35100	Түүхий эд материал		
35400	Хангамжийн материал		
36	НӨӨЦИЙН БАРАА		
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
39200	Биет хөрөнгө		
39300	Биет бус хөрөнгө		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
51	Засгийн газрын хувь оролцоо		
51200	Хуримтлагдсан үр дүн		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		

/Төгрөгөөр/

Эхний
үлдэгдэл

Эцсийн
үлдэгдэл

4317143998

МЮА0065 9055436

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	66,435,500.00	138,085,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120002	Хүүгийн орлого	-	-
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,435,500.00	138,085,200.00
1310	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,435,500.00	138,085,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,435,500.00	138,085,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,435,500.00	138,085,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,435,500.00	138,085,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,035,500.00	132,095,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	790,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	790,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,245,500.00	-
210702	Дотоод албан томилолт	1,245,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
2701	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	-	76,800,000.00
2701	ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	-	47,597,000.00
2702	Үйл ажиллагааны зардал	-	6,373,800.00
2702	Үйл ажиллагааны зардал/судалгаа/	-	1,325,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,400,000.00	5,989,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,400,000.00	5,989,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	64,400,000.00	-
2603	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,989,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	=	=

/Төгрөгөөр/

Тайлант оны гүйцэтгэл

138,085,200.00

4317143998

МНОА00659055436

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
5	Тайлант үеийн үр дүн				
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл				

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг өөр /Төгрөгөөр/ Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	66,435,500.00	138,085,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120002	Хүүгийн орлого	-	4317143998
120009	Бусад орлого	-	МНОА0065 9055436
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,435,500.00	138,085,200.00
1310	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,435,500.00	138,085,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,435,500.00	138,085,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,435,500.00	138,085,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,435,500.00	138,085,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,035,500.00	132,095,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	790,000.00	
210402	Тээвэр, шатахуун	790,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,245,500.00	
210702	Дотоод албан томилолт	1,245,500.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	
2701	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт		76,800,000.00
2701	ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт		47,597,000.00
2702	Үйл ажиллагааны зардал		6,373,800.00
2702	Үйл ажиллагааны зардал/судалгаа/		1,325,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,400,000.00	5,989,400.00
2132	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,400,000.00	5,989,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	154,820,000.00	132,095,800.00	22,724,200.00	85.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154,820,000.00	132,095,800.00	22,724,200.00	85.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	-	-
2701	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	93,534,800.00	76,800,000.00	16,734,800.00	82.1
2701	ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	51,620,000.00	47,597,000.00	4,023,000.00	92.2
2702	Үйл ажиллагааны зардал	9,665,200.00	7,698,800.00	1,966,400.00	79.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	154,820,000.00	132,095,800.00	22,724,200.00	85.3
1310	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,820,000.00	132,095,800.00	22,724,200.00	85.3
131001	Төсвөөс санхүүжих	154,820,000.00	132,095,800.00	22,724,200.00	85.3
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /цаашид Халамжийн сан гэх/ үйл ажиллагааны зорилго, зорилт, чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:



- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгож, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 363 дугаар тогтоолоор “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг шинэчлэн баталсан,
- ХХҮЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/25 дугаар тушаалаар “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ыг баталсан,


Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг боловч тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар ХХҮЕГ-ын болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн / орон нутгийн / 2022 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд *“Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байна”* гэж заасны дагуу халамжийн сангийн хөрөнгө нь зөвхөн мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл Халамжийн сангийн / орон нутгийн / санхүүгийн тайланд бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийн бусад хэлбэрүүд тусгагдаагүй байна.

Тайлант онд нийгмийн Халамжийн сангийн / орон нутгийн / санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого, зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 65,660.3 мянган төгрөгөөр буюу 2 дахин өсөж, 138,085.2 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх онд Ковид-19 цар тахал гарч, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал болон ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний зардлууд зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийн төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 154,820.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 154,820.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр эцэслэн баталжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 132,095.8 мянган төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт 16,734.8 мянган төгрөгөөр, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт 4,023.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 1,966.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж орон нутгийн төсөвт 22,724.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Сангийн зарцуулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	154,820.0	132,095.8	22,724.2	85.3
2	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,820.0	132,095.8	22,724.2	85.3
3	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн	93,534.0	76,800.0	16,734.8	82.1
4	ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	51,620.0	47,597.0	4,023.0	92.2
5	Үйл ажиллагааны зардал	9,665.2	7,698.0	1,966.4	79.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын Халамжийн сангийн /орон нутгийн төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/71 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 66,435.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 664.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Тайлант онд нийгмийн Халамжийн сангийн /орон нутгийн/ санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого, зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 65,660.3 мянган төгрөгөөр буюу 2 дахин өсөж, 138,085.2 мянган төгрөгөөр тайлагнагдсанаас шалтгаалан материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардлын 138,085.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,380.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс тайлант жилийн төсөвт орсон, нэмэлт, өөрчлөлтийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Амьжиргаа дэмжих зөвлөл”-ийн хурлаар хэлэлцсэн асуудлыг бүх гишүүдийн гарын үсгээр баталгаажуулж байх, шийдвэрийг тэтгэмжийн цахим хувийн хэрэгт хавсаргаж системд оруулж байх зэрэг 2 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт


/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бүх сумдад хүрч ажиллах боломжгүй учир Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Түшиг зэрэг 5 сумын онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний санхүүжилт, түүний зарцуулалт, цахим хувийн хэргийг түүвэрлэн шалгалаа.

Санхүүгийн тайлангийн аудитад тус халамжийн сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудлыг бүрэн хамруулсан бөгөөд халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн цахим хувийн хэрэг, тэтгэвэр, тэтгэмж тогтоолтыг иж бүрэн тулган баталгаажуулах боломжгүй тул цаашид гүйцэтгэл, нийцлийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								